

**Оюу Толгой ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал
Крэйг Киннел зэсийн баяжмал экспортолж эхэлсний нэг жилийн ойд
зориулан ажиллагсадаа хандан үг хэллээ**

2014 оны 7 дугаар сар 9 - Улаанбаатар хот



Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилье.

Юуны өмнө та бүхэндээ үндэсний их баяр наадмын мэндчилгээг дэвшүүлье. Баяр наадмаа сайхан тэмдэглэж, амралтын өдрүүдээ ая тухтай өнгөрүүлээрэй.

Баяр наадмын өдрүүдээр гэр бүл, найз нөхдийнхөө хамт сайхан амарч, наадмаас наадмын хооронд аж амьдрал, ахуй хийгээд хөгжил дэвшилдээ гарсан өөрчлөлтийн талаар ярилцаж, улам эрч хүчтэйгээр ажилдаа эргэж ирээрэй. Гэхдээ зуны энэ сайхан дэлгэр цагт амарч байх үед анхаарал амархан сарнидаг. Энэ үеэр өөрийн болон хамтран ажиллагсад, гэр бүлийнхээ аюулгүй байдалд тавих анхаарлаа бүү сулруулаарай.



Үндэсний баяр наадмын үеэр олон ой тохиож байгаа. Тулгар төрийн 2223, Их Монгол улс байгуулагдсаны 808, Ардын хувьсгалын 93 жилийн ой, мөн Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Манлай сум байгуулагдсаны 90 жилийн ой тохиож байна.

Харин манай компанийн хувьд өнөөдөр өөр нэгэн чухал ой болж байна. Нэг жилийн өмнө бид бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд экспортолж эхэлсэн. Энэ бол Оюу Толгойн болон Монголын түүхэнд үлдэх томоохон амжилт байлаа.

Өмнийн говьд өрнөсөн бүтээн байгуулалт, энэхүү амжилтад хүрэхийн тулд хийж бүтээсэн ажил үнэхээр гайхалтай байна.

Анх удаа Оюу Толгойд ирсэн цаг үеэ би тодхон санаж байна. Уул уурхайн салбарт 30 жил гаруй ажилласан миний бие гуравхан жилийн дотор ийм нүсэр бүтээн байгуулалт өрнүүлж чадсаныг хараад бахдан биширч байлаа.

Барилга бүтээн байгуулалтын оргил үед зуны аагим халуун, өвлийн тэсгим хүйтнийг үл анзааран 18 мянга гаруй хүн Оюу Толгойн бүтээн байгуулалтад гар бие оролцсон юм.

Хүнд даацын “Комацу” ачааны машинаар 7400 удаагийн зөөлт хийж, хөрс хуулсан. Хүдрийн биет олборлож эхлэхээс өмнө бид энд зургаан сая тонн буюу Зайсан толгойтой дүйцэх хэмжээний газар шорооны ажил гүйцэтгэсэн.

Үйлдвэрийн цогцолборт 581 километрийн кабель шугам орсон нь Оюу Толгойгоос Улаанбаатар хүрэх зайтай тэнцэнэ. Баяжуулах үйлдвэрээ барихын тулд бид өмнийн говь руу 23 мянган тонн ган төмөр зөөвөрлөсөн. Энэ бол Эйфелийн гурван цамхаг барихад хангалттай хэмжээний төмөр юм.

Энэ бүх амжилтад бид олон мянган ажилчдынхаа хамтын хичээл зүтгэлээр хүрсэн юм.

Оюу Толгой хэмээх энэ том айлын тоонд багтах сайхан боломж надад тохиосон.

Өнгөрсөн оны 10 дугаар сард Монголд гэр бүлийнхээ хамт нүүж ирэх үед надад төрсөн хамгийн сайхан сэтгэгдэл бол мэдлэг оюун ухаан, авьяас чадвар, эрч хүчээр дүүрэн, эх орон, компаниараа бахархдаг манай ажиллагсад байлаа.



Миний өмнө нь бодож, төсөөлж байснаас Монгол орон үзэсгэлэнт сайхан байгальтай, баялаг түүх соёлтой, үндэсний өвөрмөц онцлогтой улс гэдгийг ойлголоо. Миний төрсөн Шотланд оронтой ч олон талаар ижил төстэй мэт санагдлаа.

Оюу Толгойд ирснээс хойш есөн сарын дараа ч Оюу Толгойг болон компанийн хичээнгүй, үнэнч, ур чадвартай хамт олныг удирдаж байгаадаа би баяртай байна.

Анхны баяжмалаа экспортод гаргасан нэг жилийн ойг бид ямар байдалтай угтаж байна вэ. Ил уурхайг ашиглалтад оруулан ажиллуулахын зэрэгцээ бизнес улам бүр бэхжиж, үйл ажиллагаа жигдэрч байна.

Бид 22x0.9 мм стандарт хэмжээний зэсийн хоолойгоор дэлхийн бөмбөрцгийг таван удаа тойруулахад хангалттай хэмжээний зэсийг Оюу Толгойд үйлдвэрлээд байна. Энэ бол маш их хэмжээний зэс. Харин та бидний амжилтын үнэ цэн нь үйлдвэрлэж экспортод гаргасан бүтээгдэхүүнээр хязгаарлагдахгүй.

- Уул уурхайд аюулгүй ажиллагаа амин чухал. Оюу Толгой компани Монгол улсад аюулгүй ажиллагааны шинэ стандарт нэвтрүүлж чадсанаар бид бахархаж байна.
- Таван жилийн хугацаанд боловсрол, сургалтын салбарт 126 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулж, 13000 монгол хүн энэ хөтөлбөрөөс ашиг тусыг нь хүртлээ.
- Оюу Толгойн уурхайтай хөрш зэргэлдээ орших орон нутгийн ард иргэд, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран говийн бүс нутгийг хамтдаа хөгжүүлэх алс хэтийг харсан арга барилыг бий болгохын төлөө ажиллаж байна.
- Үйлдвэрлэлд ашиглаж буй усны 86.4 хувийг дахин боловсруулж, дусал ус бүрийг таваас доошгүй удаа дахин ашигладаг боллоо. Ингэснээр бид дэлхийн хэмжээнд хамгийн бага усны хэрэглээтэй зэсийн үйлдвэрүүдийн тоонд орж чадлаа. Өөрөөр хэлбэл, дэлхийн ижил төрлийн зэсийн уурхайнууд нэг тонн хүдэр боловсруулахдаа ашигладаг уснаас бид даруй хоёр дахин бага ус хэрэглэж байна.

Тогтвортой үйл ажиллагаа явуулах нь бизнесийн ирээдүйд ч, орон нутгийн иргэдэд ч нэн чухал.

Газар шороо, ус, говь нутгийн соёлын өвийг хамгаалах амлалт, үүргээ бид гүнээ ухамсарладаг.

- Байгалийн нөхөн сэргээлтийн ажилд бэлтгэж, 200 мянган модны суулгац тарьж, бэлтгэлээ.



- Говь нутагт усны мониторинг хийж, хамгаалахаас гадна орон нутгийн иргэд, мал амьтанд усны шинэ эх үүсвэрийг нээж илрүүлэх ажлыг хийж байна.
- Соёлын өвийн хөтөлбөр байгалийн болон түүхийн олон дурсгалт газруудыг хамгаалж, хойч үеийнхэнд үлдээхэд хувь нэмрээ оруулж байна.

Гэхдээ тогтвортой байдал гэдэг ойлголт дан ганц байгаль орчинтой холбоотой зүйл биш. Энэ бол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахдаа ирээдүйн сайн сайхныг давхар бодолцож үзэхийг хэлнэ.

Барилга бүтээн байгуулалт эхлэх үед Оюу Толгойд үндэсний ханган нийлүүлэгчийн хувь хэмжээ тун бага байсан. Харин монгол компаниудад зарцуулах худалдан авалтын хэмжээ жил бүр нэмэгдсээр энэ жил 59 хувь хүртэл өсөх төлөвтэй байна.

Орон нутгийн олон компаниуд өсч хөгжихийн хэрээр ирээдүйд төрөлжсөн эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

Нэг сая ам.долларын бичил санхүүгийн сан, бизнесийн хөгжилд үзүүлэх зөвлөгөөгөөр дамжуулан дүрэмт хувцасны үйлдвэрээс малчдын хоршоо хүртэл орон нутгийн эдийн засгийн хөгжилд хөрөнгө оруулж байна.

Бид Өмнөговь аймгийн Ханбогд сумыг байнгын эрчим хүчтэй холбосон. Уурхайгаас сумын төв хүртэл хар зам барихаар төлөвлөж байна. Энэ нь Ханбогдын хөгжлийг хурдасгахын зэрэгцээ манай компанийн ажилчид гэр бүлийн хамтаар тэнд амьдрах нэг боломжийг нээж байна.

Үйлдвэрлэлээ явуулсан энэ богино хугацаанд бид хамтдаа нэлээд урт замыг даван тууллаа. Мэдээж, өнгөрсөн жил бид бас олон сорилттой тулгарсан.

Энэ оны тавдугаар сард бид бүтцийн өөрчлөлт хийж, зарим хамтран зүтгэгчдэдээ баяртай гэж хэлэхэд хүрсэн нь амаргүй шийдвэр байлаа. Гэхдээ аюулгүй, тогтвортой, ашигтай, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай бизнесийн байгууллага болохын тулд эдгээр өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлагатай тулгарсан юм.

Одоо ирээдүйнхээ талаар хэдэн үг хэлье. Манай бизнест 100, түүнээс ч олон жил ажиллах нөөц бололцоо бий. Хүнээр бол бид одоо дөнгөж өсч буй бяцхан хүүхэд л гэсэн үг. Цаашид энэ хүүхэд өсч том болно. Нас ахихын хэрээр туршлага хуримтлуулж, илүү их



ухаан сууна. Бидэнд хийх ажил их байна, хамтдаа бид олон сорилтыг даван туулж хичээл зүтгэл гарган ажиллах болно.

Гэхдээ бидний хийж бүтээсэн ололт амжилт нь аюулгүй, амжилттай түншлэл бий болгон, дэлхийн хамгийн шилдэг ордын нэгийг хөгжүүлэх эхлэл болсон гэдэгт би бүрэн итгэлтэй байдаг.

Барилга бүтээн байгуулалтын төгсгөл, баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулсны ой, үйлдвэрлэлийн эхлэл гэх зэргээр бизнесийн бүхий л үе шат, цаашид ажиллах хугацаанд бидний үр хүүхэд, ач зээ нар ч олон чухал ойг тэмдэглэх болно.

Цаашид ч олон чухал амжилт гарна. Харин өнөөдрийг бид мөнхөд тэмдэглэх учиртай. долдугаар сарын 9-ний энэ өдөр бол Оюу Толгой хэмээх бизнес жинхэнэ ёсоор мэндэлсэн өдөр гэж түүхэнд үлдэх болно.

Бид хамтдаа хийж бүтээсэн, гаргасан ололт амжилтаараа бахархаж, цаашид хийж бүтээх олон зүйлийг сэтгэл догдлон хүлээх учиртай. Бизнесийн үйл ажиллагаа сайжрах тусам та бүхэн, манай ажиллагсад энэ бизнесийн хамгийн үнэ цэнтэй хөрөнгө байх болно.

Улаанбаатарт болон гэр бүлээсээ хол олон өдөр, шөнө уурхайд ажиллаж байгаа та бүхний хичээл зүтгэлээр энэ бүх амжилтад хүрсэн юм. Өдөр бүр хичээл зүтгэл, бахархал, халамжтай ажиллаж байгаа та бүхэндээ талархлаа илэрхийлье.

Оюу Толгойн төрсөн өдрийн мэндийг та бүхэнд хүргэж Үндэсний их баяр наадмын мэндийг дэвшүүлье. Сайхан наадаарай.